



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 9/86

Мандалговь

Түр хамгаалах байрны үйл ажиллагааг
санхүүжүүлэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 8.1.2 дахь заалт аймгийн ИТХ-ын 2018 оны 16 дугаар тогтоол, 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн Хамтран ажиллах гурвалсан гэрээний 2.1.2-т тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Түр хамгаалах байрны үйл ажиллагааны төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах 1,800,000 (нэг сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн 2019 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын "Хөтөлбөр арга хэмжээ"-ний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат)-т, гурвалсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Нарантуяа)-т тус тус даалгасугай.

Хоёр. Түр хамгаалах байрны үйл ажиллагааны төслийн дагуу гурвалсан гэрээнд заасан хугацаанд үйл ажиллагааг чанартай зохион байгуулахыг Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын тэргүүн (Б.Сувд), Гэр бүл, хүүхэд, залуучууд хөгжлийн газрын дарга (Ц.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190253